Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БӨА-2024/162/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: У.Ербол<br>Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ........
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........
3. Санхүүгийн тайлангийн тодруулга........
    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........
    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин........
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........
    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт........
4. Аудитын тайлан ........
    4.1 Ерөнхий зүйл ........
    4.2 Материаллаг байдал ........
    4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........
    4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........
    4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........
    4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........
5. Аудитын илрүүлэлт ........
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ........


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.22 № 169
танай ____________-ны № ____________-т

САГСАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Т.НУРЛАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй

**Аудитын гол асуудал**

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402254

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **171,199,522.79** | **135,681,299.11** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 48,683,886.03 | 32,196,614.88 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 48,683,886.03 | 32,196,614.88 |
| **3121** | **Төгрөг** | 48,683,886.03 | 32,196,614.88 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 48,683,886.03 | 32,196,614.88 |
| **33** | **АВЛАГА** | 18,815.00 | 15,372,439.41 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 18,815.00 | 19,982.41 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 11,448,457.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 3,904,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 3,904,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 122,496,821.76 | 88,112,244.82 |
| **351** | **Түүхий эд материал** | 88,677,642.76 | 54,958,664.82 |
| 35130 | Эм боох материал | 88,677,642.76 | 54,958,664.82 |
| **354** | **Хангамжийн материал** | 33,819,179.00 | 33,153,580.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,676,269.00 | 2,845,499.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,112,850.00 | 22,170,051.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,250,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 9,630,060.00 | 7,020,030.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 150,000.00 | 1,118,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **855,914,572.81** | **896,075,727.99** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 855,914,572.81 | 896,075,727.99 |
| **392** | **Биет хөрөнгө** | 838,439,406.18 | 878,609,728.03 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 822,265,317.00 | 822,265,317.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (115,571,652.90) | (136,744,925.45) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 120,764,994.00 | 123,864,994.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (61,130,996.24) | (75,138,661.85) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 104,187,685.85 | 179,320,684.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (40,538,546.12) | (43,212,392.19) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,618,815.00 | 27,618,815.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,264,210.41) | (19,472,103.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 458,000.00 | 458,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (350,000.00) | (350,000.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 17,475,166.63 | 17,465,999.96 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (100,833.37) | (110,000.04) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,026,000.00 | 17,026,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,027,114,095.60** | **1,031,757,027.10** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **43,049.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 43,049.00 |
| **413** | **Өглөг** | - | 43,049.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 43,049.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 21,299.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 21,750.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,027,114,095.60** | **1,031,713,978.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,027,114,095.60 | 1,031,713,978.10 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 590,926,695.50 | 590,926,695.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 590,926,695.50 | 590,926,695.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (115,440,590.87) | (110,937,808.37) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (224,679,536.70) | (110,937,808.37) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 109,238,945.83 | 4,599,882.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 551,627,990.97 | 551,725,090.97 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,027,114,095.60** | **1,031,757,027.10** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **943,452,136.89** | **961,801,860.64** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **145,639,086.89** | **69,059,691.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 145,639,086.89 | 69,059,691.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 145,639,086.89 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 73,510,720.80 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 72,128,366.09 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 66,368,999.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 2,690,692.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **797,813,050.00** | **892,742,169.64** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 290,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 290,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,350,100.00 | 31,314,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,350,100.00 | 31,314,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 768,172,950.00 | 861,428,069.64 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 768,172,950.00 | 861,428,069.64 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **820,219,191.06** | **957,201,978.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **820,219,191.06** | **957,201,978.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 813,983,601.06 | 955,926,287.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 475,574,431.35 | 606,033,282.68 |
| 210101 | Үндсэн цалин | 397,620,030.16 | 444,769,979.46 |
| 210102 | Нэмэгдэл | 59,777,262.99 | 123,677,892.57 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,910,000.00 | 5,900,000.00 |
| 210104 | Урамшуулал | 15,267,138.20 | 31,685,410.65 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,594,770.10 | 76,579,663.16 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,884,443.94 | 52,131,434.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,927,582.00 | 6,133,204.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,942,066.00 | 4,906,563.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 985,515.16 | 1,218,950.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,855,163.00 | 12,189,509.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,694,857.00 | 23,836,409.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,576,457.00 | 3,386,409.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,118,400.00 | 20,450,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 93,744,572.72 | 64,586,710.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 25,988,847.00 | 4,862,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 62,933,175.72 | 55,052,960.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,511,150.00 | 1,606,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,311,400.00 | 3,065,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 99,568,225.32 | 122,350,208.48 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 83,215,531.27 | 103,882,228.48 |
| 210502 | Хоол, хүнс | 15,370,694.05 | 18,467,980.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 982,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,214,691.00 | 18,586,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,555,191.00 | 13,572,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,659,500.00 | 5,013,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,327,400.00 | 1,085,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,327,400.00 | 1,085,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 820,120.00 | 75,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 94,120.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 104,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 102,000.00 | 75,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,444,533.57 | 42,794,013.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,519,840.00 | 4,722,170.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,924,693.57 | 38,071,843.82 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,235,590.00 | 1,275,691.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,235,590.00 | 1,275,691.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,235,590.00 | 1,275,691.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 123,232,945.83 | 4,599,882.50 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 123,232,945.83 | 4,599,882.50 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **797,813,050.00** | **881,293,712.64** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **797,813,050.00** | **881,293,712.64** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 290,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 290,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,350,100.00 | 31,314,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,350,100.00 | 31,314,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 768,172,950.00 | 849,979,612.64 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 768,172,950.00 | 849,979,612.64 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **747,763,986.97** | **885,916,983.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **747,763,986.97** | **885,916,983.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **741,528,396.97** | **884,641,292.79** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 478,924,805.97 | 609,098,889.06 |
| 210101 | Үндсэн цалин | 308,840,200.00 | 332,960,089.59 |
| 210102 | Нэмэгдэл | 121,010,953.97 | 206,885,773.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,592,446.00 | 7,978,000.00 |
| 210104 | Урамшуулал | 42,481,206.00 | 59,900,801.28 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 1,374,225.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 57,115,993.00 | 73,515,224.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,244,088.88 | 50,163,271.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,533,392.96 | 5,870,351.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,568,642.59 | 4,856,615.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 925,297.28 | 1,147,739.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,844,571.29 | 11,477,245.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,144,857.00 | 26,490,409.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,494,057.00 | 3,386,409.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,650,800.00 | 23,104,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 66,225,288.00 | 59,494,180.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,748,293.00 | 3,819,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 54,990,900.00 | 50,797,380.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,510,400.00 | 1,606,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 432,400.00 | 324,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,543,295.00 | 2,947,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 100,908,664.00 | 84,253,545.54 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 75,025,700.00 | 67,736,345.54 |
| 210502 | Хоол, хүнс | 16,702,964.00 | 15,782,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,180,000.00 | 735,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,482,559.00 | 20,397,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,501,686.00 | 13,544,600.00 |
| 210602 | Тавилга | | 6,852,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,980,873.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,327,400.00 | 1,085,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,327,400.00 | 1,085,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 820,120.00 | 75,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 94,120.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 104,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 102,000.00 | 75,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,578,710.00 | 10,231,545.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,578,710.00 | 10,231,545.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,235,590.00** | **1,275,691.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 1,275,691.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,275,691.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,235,590.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,235,590.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **50,049,063.03** | **(4,623,271.15)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,350,000.00** | **11,864,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,350,000.00** | **11,864,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,350,000.00 | 11,864,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,350,000.00 | 11,864,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,350,000.00)** | **(11,864,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 47,699,063.03 | (16,487,271.15) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 984,823.00 | 48,683,886.03 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 48,683,886.03 | 32,196,614.88 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 590,926,695.50 | 551,627,990.97 | -238,868,236.70 | | 903,686,449.77 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 14,091,600.00 | | 14,091,600.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **590,926,695.50** | **551,627,990.97** | **-224,776,636.70** | **0.00** | 917,778,049.77 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | 97,100.00 | | | 97,100.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 109,238,945.83 | | 109,238,945.83 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **590,926,695.50** | **551,725,090.97** | **-115,537,690.87** | **0.00** | 1,027,114,095.60 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **590,926,695.50** | **551,725,090.97** | **-115,537,690.87** | **0.00** | 1,027,114,095.60 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **590,926,695.50** | **551,725,090.97** | **-115,537,690.87** | **0.00** | 1,027,114,095.60 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 4,599,882.50 | | 4,599,882.50 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **590,926,695.50** | **551,725,090.97** | **-110,937,808.37** | **0.00** | 1,031,713,978.10 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 48,683,886.03 | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,033,395,686.03 | 896,505,292.79 | 136,890,393.24 | 86.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,033,395,686.03 | 896,505,292.79 | 136,890,393.24 | 86.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,033,395,686.03 | 896,505,292.79 | 136,890,393.24 | 86.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 660,479,100.00 | 609,098,889.06 | 51,380,210.94 | 92.2 |
| 210101 | Үндсэн цалин | 342,574,100.00 | 332,960,089.59 | 9,614,010.41 | 97.2 |
| 210102 | Нэмэгдэл | 231,126,500.00 | 206,885,773.19 | 24,240,726.81 | 89.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,748,000.00 | 7,978,000.00 | 2,770,000.00 | 74.2 |
| 210104 | Урамшуулал | 76,030,500.00 | 59,900,801.28 | 16,129,698.72 | 78.8 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 1,374,225.00 | (1,374,225.00) | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 84,894,000.00 | 73,515,224.19 | 11,378,775.81 | 86.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,728,300.00 | 50,163,271.97 | 7,565,028.03 | 86.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,791,300.00 | 5,870,351.98 | 920,948.02 | 86.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,433,400.00 | 4,856,615.38 | 576,784.62 | 89.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,358,100.00 | 1,147,739.09 | 210,360.91 | 84.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,582,900.00 | 11,477,245.77 | 2,105,654.23 | 84.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,705,100.00 | 26,490,409.00 | 1,214,691.00 | 95.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,601,100.00 | 3,386,409.00 | 1,214,691.00 | 73.6 |
| 210302 | Түлш, халаалт | 23,104,000.00 | 23,104,000.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 81,111,000.00 | 59,494,180.00 | 21,616,820.00 | 73.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,791,400.00 | 3,819,700.00 | 971,700.00 | 79.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 70,913,600.00 | 50,797,380.00 | 20,116,220.00 | 71.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,459,000.00 | 1,606,100.00 | (147,100.00) | 110.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 324,000.00 | (324,000.00) | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,947,000.00 | 2,947,000.00 | 1,000,000.00 | 74.7 |
| **2105** | **Нормативт зардал** | 115,651,000.00 | 84,253,545.54 | 31,397,454.46 | 72.9 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,114,400.00 | 67,772,345.54 | 30,342,054.46 | 69.1 |
| 210502 | Хоол, хүнс | 16,801,600.00 | 15,746,200.00 | 1,055,400.00 | 93.7 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 735,000.00 | 735,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 32,756,900.00 | 22,397,500.00 | 10,359,400.00 | 68.4 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,397,900.00 | 15,544,600.00 | 8,853,300.00 | 63.7 |
| 210604 | Урсгал засвар | 8,359,000.00 | 6,852,900.00 | 1,506,100.00 | 82.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,499,000.00 | 1,085,000.00 | 414,000.00 | 72.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,499,000.00 | 1,085,000.00 | 414,000.00 | 72.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху** | 571,900.00 | 75,000.00 | 496,900.00 | 13.1 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 140,000.00 | | 140,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 140,000.00 | | 140,000.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 189,900.00 | | 189,900.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 102,000.00 | 75,000.00 | 27,000.00 | 73.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 28,727,686.03 | 20,095,545.00 | 8,632,141.03 | 70.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,727,686.03 | 20,095,545.00 | 8,632,141.03 | 70.0 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 984,711,800.00 | 880,018,021.64 | 104,693,778.36 | 89.4 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 31,314,100.00 | 30,038,409.00 | 1,275,691.00 | 95.9 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 31,314,100.00 | 30,038,409.00 | 1,275,691.00 | 95.9 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САІ** | 953,397,700.00 | 849,979,612.64 | 103,418,087.36 | 89.2 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 953,397,700.00 | 849,979,612.64 | 103,418,087.36 | 89.2 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 48,683,886.03 | (48,683,886.03) | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 48,683,886.03 | 32,196,614.88 | 16,487,271.15 | 66.1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 37 | 38 | (1) | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 28 | 28 | - | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | - | |
| 620004 | Гэрээт ажилтан | | 1 | (1) | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **37** | **38** | (1) | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭ | 29 | 29 | - | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 8 | - | |
| 650010 | Гэрээт ажилтан | | 1 | (1) | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвөөс гүйлгээ гараагүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:***

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь “Эмч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, үзлэг шинжилгээний дүгнэлтийн чанар, хууль шинжлэх ухааны үндэслэлийг ахиулахад онцгой анхаарч ажиллана” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Байгууллагын бүтэц тогтолцоог оновчтой зохион байгуулж , үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- Материаллаг баазыг бэхжүүлж, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцоход цахим сүлжээ өргөнөөр ашиглах,
- Хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

Чиг үүрэг нь: Хүн амд эрүүл мэндийн анхны тусламж үйлчилгээг хүргэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант онд Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны А/09 дугаар тушаалаар баталсан ”Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,642.9 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 48,683.8 | 32,196.6 | (16,487.3) |
| Авлага | 18.8 | 15,372.4 | 15,353.6 |
| Бараа материал | 122,496.8 | 88,112.2 | (34,384.6) |
| Үндсэн хөрөнгө | 855,914.6 | 896,075.7 | 40,161.2 |
| **Нийт хөрөнгө** | **1,027,114.1** | **1,031,757.0** | **4,642.9** |
| Өр төлбөр | 0 | 43.0 | 43.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,027,114.1 | 1,031,713.9 | 4,599.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,027,114.1** | **1,031,757.0** | **4,642.9** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл оны эцэст 32.2 сая төгрөг болж 16.5 сая төгрөгөөр буурсан байна.

Дансны авлага 15.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 11.4 сая төгрөг, түлш халаалтын авлага 3.9 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 88.1 сая төгрөг болж 34.4 сая төгрөгөөр буурсан нь эм, боох материалын зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 40.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ОНХС-аас нийлүүлсэн 15.0 сая төгрөгийн цусны гемотиологийн анализатор, 32,8 сая төгрөгийн хэвлийн суурин эко аппарат, 5.1 сая төгрөгийн автоклав ком, 3.1 сая төгрөгийн мотоцикл, болон бусад тоног төхөөрөмжтэй холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 4.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас 953.4 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 31.3 сая төгрөгийн санхүүжилт авахаар төсвийн төсөл боловсруулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн эрхийг 953.4 сая төгрөгөөр нээж, 31.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 849.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст орон нутгийн төсвөөс 1.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 886.5 сая төгрөг буюу 86.5 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **71602** | **Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **1,002,081.6** | **866,466.9** | **135,614.7** | **86.5%** |
| 80302 | Нэг иргэнд ноогдох норматив | 729,031,0 | 689,780.9 | 39,250.1 | 94.6% |
| 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 256,114.9 | 140,874.2 | 115,240.7 | 55% |
| 83603 | Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан | 16,935.6 | 35,811.8 | (18,876.2) | 211.5% |
| 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 31,314.1 | 30,038.4 | 1,275.7 | 95.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвөөр гүйлгээ хийгдээгүй байна.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сагсай сумын Эрүүл мэндийн төв 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 167.2 сая төгрөгийн бараа материал, 11.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай  холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 820.2  сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулж, жилийн эцэст өр, авлагагүй ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 856,733.1 мянган төгрөгийн 32 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18,594.7 мянган төгрөгийн 3 гүйлгээг байршуулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдэж, аудитаар илэрсэн зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгав.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт 1, хариуцлага тооцох 2 албан шаардлага, 1 зөвлөмж хэрэгжилтийг давтан шалгахад биелэлтийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 2,678.4 | 1 | 2,678.4 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хариуцлага тооцох албан шаардлага | 2 | 282,982.6 | 2 | 282,982.6 | 100% |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 100% |
| **Нийт дүн** | **4** | **285,661.0** | **4** | **285,661.0** | 100% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитаар эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн тул төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,490.4 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 26,490.4 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн түлш халаалт, гэрэл цахилгааны зардлын 26,490.4 мянган төгрөгт тохируулгын бичилт хийгдээгүйгээс дутуу тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 2,706.1 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 2,706.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 5.1 Төлбөрийн акт

Дарга, нягтлан бодогч нар 2023 онд сахилгын шийтгэлтэй байсан хугацаанд үр дүнгийн урамшуулалд 2,706.1 мянган төгрөгийг төсвөөс үндэслэлгүй хууль бусаар авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",* 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т *“төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”,* Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “ Төрийн албан хаагчдад урамшуулал олгох журам”-ын 2.7-т “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Байхгүй

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.3 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд гэрэл цахилгаан, түлш халаалт, дутуу тайлагнасан | 1 | 26,490.4 | | | 1 | 26,490.4 | 1 | 26,490.4 | | | | |
| **Дүн** | **1** | **26,490.4** | | | **1** | **26,490.4** | **1** | **26,490.4** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сахилгын шийтгэлтэй албан хаагч үр дүнгийн урамшуулал авсан | 1 | 2,706.1 | 1 | 2,706.1 | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **2,706.1** | **1** | **2,706.1** | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |